



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81. Факс: (976-11) 33 07 80.
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2022. 12. 23. № 04/2324
танай _____-ны № _____-т

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН
ГЭГЭЭРҮҮЛЭХ ХЭЛТЭСТ**

Тус яамны Авлигын эсрэг үйл ажиллагааны
2022 оны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлж
байна.

Төлөвлөгөөний биелэлтийг Авлигын эсрэг
үндэсний сүлжээ <http://khutulbur.iaac.mn/iaac/plan/>
цахим системд баталгаажуулсан болно.

Хавсралт 8 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА



Б.БАТЦЭЦЭГ

1522097314

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
04/2324 дугаартай албан бичгийн хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

9022010239 6806252 АМТ06231
2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфо болон видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, youtube суваг), мөн сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;	Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны чиглэлээр бэлтгэсэн аудио зөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд тухай бүрд байршуулж шинэчилж ажилласан. Мөн авлигын эсрэг ухуулга бүхий зурагт хуудсыг байгууллагын дотор хананд нааж албан хаагчид, байгууллагаар үйлчлүүлж буй иргэд уншиж танилцах боломжоор хангасан.
		1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн загварын дагуу байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.
		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;	Авлигын эсрэг самбарыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Авлигатай тэмцэх газраас хүлээн авч байгууллагын 2 давхарт байршуулсан бөгөөд мэдээ, мэдээллийг тухай бүрд шинэчлэн ажилласан.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах	2.1.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн сургалтын зарын дагуу албан хаагчдыг хамруулах сургалтын санал, захиалгыг хүргүүлсэн байх;	Тайлант хугацаанд албан хаагчдыг сургалтад хамруулах талаар Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар М.Жамъянчойжил холбогдсон. Тус яаманд 2022 оны 05 дугаар сард ажиллаж байсан албан хаагчдыг 2021 онд нийтийн албан тушаалтныг авлигаас урьдчилан сэргийлэх тухай ойлголт өгөх Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулсан

	сургалтад хамруулах		байсан тул сул орон тоог нөхсөний дараа сургалтыг зохион байгуулахаар харилцан тохиролцсон. Яамны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2022 оны 07, 09, 12 сард тус тус зохион байгуулсан ба сургалтыг цахим хэлбэрээр авахаар тов хүлээж байна.
		2.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;	Яамны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2022 оны 07, 09, 12 сард тус тус зохион байгуулсан ба сургалтыг цахим хэлбэрээр авахаар тов хүлээж байна.
		2.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;	Авлигаас сэргийлэх талаар гарын авлагыг томилогдохоос өмнө томилогдсоны дараа цахим шуудангийн хаягаар нь хүргүүлж заавал танилцах материалд мэдүүлэг гаргагчид зориулсан цахим гарын авлагыг оруулж албан хаагч танилцсан байх боломжоор хангаж ажилласан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам шинээр байгуулагдсантай холбоотойгоор яамны шууд харьяанд ажиллах Үндэсний дата төв УТҮГ, Радио, телевизийн сүлжээ УТҮГ, И-Монгол академи УТҮГ-ын эрх бүхий албан тушаал эрхэлж байгаа 40 албан хаагчийн хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг шинээр гаргуулах хүрээнд тус байгууллагуудад салбар ЭБАТ томилуулан, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр салбар ЭБАТ-уудад сургалт зохион байгуулсан. Салбар ЭБАТ-уудад шаардлагатай дүрэм, журмыг танилцуулж, жишиг материалуудыг имэйлээр хүргүүлж ашиглах боломжоор хангасан.
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд шаардсан мэдээ мэдээллийг өгөх, холбогдох албан тушаалтнуудыг холбох зэрэг арга хэмжээг шуурхай зохион байгуулах	-Авлигатай тэмцэх газраас тус яамны үйл ажиллагааны ил тод байдал, байгууллагын шударга байдлын түвшнийг нэмэгдүүлэх, авлигын эрсдэлийг тодорхойлох, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, шалган туслах, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсэг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд байрлан ажиллаж байна. Ажлын хэсэгтэй хамтран ажиллаж шаардсан мэдээллийг тухай бүрд гаргаж, албан хаагчдыг хариуцсан чиглэлээр нь холбож ажилласан. Ажлын хэсэг 2022 оны 9 дүгээр сарын 16, 22, 29-ний өдрүүдэд яаманд байрлаж ажиллан, албан хаагчдын хувийн хэрэг, өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн байдал, албан хаагчдын томилгооны

			тушаал шийдвэр, санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай албан хаагчдын жагсаалтыг гаргуулж танилцсан. -Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-д туссан тус яамнаас хариуцан хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөөний өөрийн үнэлгээ болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт тус яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл оролцсон. -Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаас 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн удирдлага, албан тушаалтнуудыг хүлээн авч уулзан, цаашид хамтран ажиллах талаар санал солилцсон. -Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдсантай холбогдуулан харьяа байгууллагын удирдах албан тушаалтан болон Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан эрх бүхий албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг гаргуулах, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг байгууллага бүрд томилох чиглэлийг Авлигатай тэмцэх газраас өгсний дагуу Үндэсний дата төв УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, И-Монгол академи УТҮГ-ын холбогдох албан тушаалтны мэдээллийг нэгтгэн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/2069 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж зөвлөмж авсан. Зөвлөмжийн хүрээнд салбар ЭБАТ-ыг томилуулж, цахим системд эрх үүсгэн, удирдах албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг шинээр гаргуулан баталгаажуулсан.
--	--	--	--

4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас тус газарт хандан гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдэх;	Авлигатай тэмцэх газраас зарласан "Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээлэл цуглуулах, тайланг бэлтгэж, үр дүнг олон нийтэд мэдээлэх" тендерийн Багц 1-т шалгарсан Бодлогын шийдэл ТББ-аас шаардсан мэдээ мэдээллийг гаргаж өгч хамтран ажилласан.
		4.2.Олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлуулах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дүгээр сарын 18-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар "Яамнаас бусад байгууллага, иргэнтэй байгуулах гэрээний загвар, холбогдох маягтууд"-ыг шинээр батлуулан мөрдсөн. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг нээлттэй хэлбэрээр, төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулдаг ба Сангийн сайдын тушаалаар баталсан аргачлал, жишиг баримт бичгийг гэрээ хэлэлцээр байгуулахдаа тогтмол ашиглаж байна. Түүнчлэн аливаа гэрээ хэлэлцээрт дор дурдсан агуулгатай хэсгийг тогтмол оруулах талаар албан хаагчдад заавар зөвлөгөө өгч, гэрээний төслийг Хуулийн хэлтсээс хянаж ажилласан: "Энэхүү гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд талууд ашиг сонирхлын зөрчилтэй аливаа саналыг харилцан тавихыг хориглоно. Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх явцад авлига, ашиг сонирхлын зөрчил, аливаа хууль бус үйлдэл гарсан тохиолдолд хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч гэрээг цуцлах үндэслэл болно. Зөвлөх, түүний нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь энэ гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш энэ үйлчилгээнээс үүсэлтэй, эсхүл түүнтэй нягт холбоотой аливаа төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэ үйлчилгээ болон түүний үргэлжлэлээс бусад)-ний гүйцэтгэгчээр ажиллах эрхгүй болохыг зөвлөх хүлээн зөвшөөрч байна."
		4.3.Яамны ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудаст байршуулах	Байгууллагын цахим хуудасны "Ил тод байдал" цэсийн "Хүний нөөцийн ил тод байдал" дэд цэсэд "Сул орон тооны зар"

		https://mddc.gov.mn/mn/%d1%81%d1%83%d0%bb-%d0%be%d1%80%d0%be%d0%bd-%d1%82%d0%be%d0%be%d0%bd%d1%8b-%d0%b7%d0%b0%d1%80/ -ыг үүсгэж, Төрийн албаны зөвлөлийн шалгалтын цахим систем https://hh.csc.gov.mn/?sector_id=02001022&offset=1&limit=100 -тэй холбосон. Засгийн газраас баталсан яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн дагуу яамны зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл, орон тоог Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дугаар тушаалаар батлуулан төрийн захиргааны 78 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн нь тус зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн А/05, А/06, А/07, А/08 дугаар тушаалаар “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт”-ыг тус тус батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлах зөвшөөрлийг авсан. Тус яам нь 6 газар, 8 хэлтсийн 87 албан хаагчийн орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд батлагдсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын нэгжийн бүтэцтэй холбоотойгоор гүйцэтгэх албан тушаалын 50, удирдах албан тушаалын 4 сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалга хүргүүлж, Салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг нийт 3 удаа зохион байгуулсан. 2022.11.30, 2022.12.07-ны өдрийн албан бичгээр гүйцэтгэх 8 сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг ТАЗ-д хүргүүлээд байна. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу өөр байгууллагаас 3 албан хаагчийг шилжүүлэн, 2 албан хаагчийг сэлгэн томилсон.
--	--	---

		4.4.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллах, тайланг тогтоосон хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Хөтөлбөрт туссан арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийн тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, Авлигын эсрэг үндэсний сүлжээ http://khutulbur.iaac.mn/iaac/home/ цахим системд оруулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудал, яамны чиг үүрэгт хамааралгүй болон бүрэн хэрэгжсэн арга хэмжээнүүдийг хасуулах саналыг тухай бүрд хүргүүлж ажилласан.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1.Албан тушаалын чиг үүргийн хүрээнд тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх сургалтад хамруулах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн суурь мэдлэг олгох худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх эрх олгох сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.
		5.2.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	Тайлант хугацаанд 7 үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулснаас хөндлөнгийн гишүүний төлөөллөөр Хүүхэд залуучуудын хөгжил хамгаалал ТББ, Бидний бүрэн Монол ТББ, ХУД Яармаг ТББ, Сэтгэлзүй судалгаа мэдээллийн төв ТББ, Хүний хөгжил, судлагаа сургалтын төв ТББ, Монголын геологийн эмэгтэйчүүдийн холбоо ТББ-ын 8 гишүүнийг Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр санал тавьж ажиллуулсан байна.
		5.3.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх	Албан хаагчдаас газрын даргын тушаалын дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажлын хэсэг, үнэлгээний хороонд ажиллах, төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийг шалгах хяналт шалгалт, байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд захиалагчийг төлөөлөн ажиллуулахаар томилолтоор ажиллуулахад хувийн ашиг сонирхол байгаа эсэх талаар тодруулж мэдэгдэл тайлбарыг бичгээр гаргуулан авсан. Мэдэгдэл тайлбарыг хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем, Шилэн дансны цахим системд хуулийн хугацааг баримтлан бүртгэж байна.
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй	6.1.Салбарын үйл ажиллагааг зохицуулах хуулийн төсөл, газрын даргын тушаалаар батлах хэм хэмжээний актын төсөлд	Байгууллагын цахим хуудсанд боловсруулж байгаа хууль, хэм хэмжээний актын төсөлд санал авахад зориулж дэд бүлэг

байдлыг сайжруулах	сонирхогч этгээдээс санал өгөх боломжийг бүрдүүлэх	https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%b b%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/ -д үүсгэсэн.
	6.2.Салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд баримтлах хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, сонирхогч этгээдийг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх	Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд батлах нийтээр дагаж мөрдөх 19 хэм хэмжээний акт (8 журам, 3 шаардлага, 4 аргачлал, 4 жагсаалт)-ыг баталсан. Тус актуудыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснийг байгууллагын цахим хуудас https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%b b%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/ -д байршуулсан.
	6.3.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд гаргаж байгаа аливаа шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаал, шийдвэрийг цахим хуудсанд байршуулах	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын төрийн болон албаны нууц, хүний хувийн нууцад хамааруулснаас бусад тушаалыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.
	6.4.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсанд мэдээллийг байршуулах	Байгууллагын цахим хуудасны “Ил тод байдал” цэсийн “Үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсэд “Өргөдөл, гомдол шийдвэрлэлт” https://mddc.gov.mn/mn/%d3%a9%d1%80%d0%b3%d3%a 9%d0%b4%d3%a9%d0%bb-%d0%b3%d0%be%d0%bc%d 0%b4%d0%be%d0%bb-%d1%88%d0%b8%d0%b9%d0%b 4%d0%b2%d1%8d%d1%80%d0%bb%d1%8d%d0%bb%d1 %82/ талбар үүсгэж Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хандан хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга болон шийдвэрлэлтийн тайланг байршуулсан. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд нийт 308 санал, хүсэлт, гомдол ирснээс 299 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 9 өргөдөл, гомдлыг холбогдох албан хаагчид шилжүүлсэн. Тайлант хугацааны байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 96,2 хувьтай байна.

			Мөн 64 өргөдөл, гомдол бичгээр ирсэн ба үүнээс 15 нь иргэдээс, 49 нь яамны албан хаагчдаас ирсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног буюу өмнөх оны шийдвэрлэлтийн хугацаанаас 2 хоногоор багассан ахиу үзүүлэлттэй байна.
--	--	--	---